Батлав.....

УЛСЫН ШАЛГАЛТ - 2018

МОНГОЛ ХЭЛ-12

Аймаг / дүүрэг: .....
Сум .....
Сургууль: .....
Анги: ..... Бүлэг: .....
Овог: .....
Нэр: .....

САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

- Шалгалт 80 минут үргэлжилнэ.
- Шалгалтын материал хоёр хэсэгтэй ба нэгдүгээр хэсэг нь унших чадвар сорьсон, хоёрдугаар хэсэг нь бичих чадвар сорьсон задгай хэлбэрийн даалгавраас бүрдэнэ.
- Даалгавар бүрийн хариултыг өгөгдсөн сул зайд бичиж тэмдэглэнэ.

ТА БҮХЭНД АМЖИЛТ ХҮСЬЕ

Ай Дарьганга нутаг минь

Шилийн Богдын орой дээр гарахад хүйтэн, хүчтэй салхитай байв. Дөрвөлжин дэвсэг бүхий орой дээр нь хадаг яндар болсон овоо байна. Идээ ундаа засаж, энд тэндээс түмний хүслийг шингээн туг хиур салхинд дарцаглаад, овоо тахилга амь сүлдтэй нэгэн төдийгүй, хэзээ хэзээгүй нисэх гэж өндөлзөн буй мэт сүртэй.(1)

Богдын орой дээрээс чанх урагш харлаа. Торгон элсэн дээгүүр шигүү шүдтэй самаар татсан юм шиг зурвас харагдана.(2)

Энэ бол миний эх орны хилийн дээс. Үүнээс цааш хүний нутаг бий. Хоёр нүдний дурангаар ийш тийш нэлээн хараачлав. Уул нь маниас өөр олигтой нүдтэй хүнд бол дурансаад байх юмгүй. Эгээ урьд өлмийн дор минь л хүний нутаг байгаа юмсанж. Улалмжлат ахуй амьдралынх нь хэв шинж болсон газар тариалангийн аж ахуй эрхэлж, шоо дөрвөлж татсан газарт хүмүүс өөвийн бөөвийн харагдана. Хаа газрын амьтас даа, амьдрахын төлөө амсхийх завгүй л тонголзож буй нь тэр биз ээ.(3)

Өвөрлөгчийн нутгаас наагуур хүн, малгүй зэлүүд. Намрын эхэн сар хэр нь өвс ногоо нь сөлтэй, талын мансуурам сайхан үнэр салхин үзүүрээр ирнэ. Хүйс хүйсхэн үлээх салхи тал дээгүүр хүүгж Богдын орой дээр амсхийн, эргээд л мянган уулын оройг дамжин буцаж буй мэт санагдана.(4)

Тахилга сүлдэндээ мөргөв. Идээ цагаагаа дээжлэн өргөв. Ижийгээ даатгав. Хань ижил, үр хүүхдээ даатгав. Ах дүү, амин холбоо, эх орноо даатгав. Мөн уул, тал, хөндий, лус савдаг бүхэнд дуугаа хүргэх гэж хоёр алгаараа салхи хааж байгаад “үү үү” хэмээн хашгирав. Хариугүй дуу минь уулсын оройгоос оройг дамжин цуурайтах шиг болсон. Санаа амарч сэтгэлийн бөглөө арилах шиг. Эх орны дорно хязгаарын алтан хаалга, мөнгөн хаяавч болсон Богдын орой дээрээс хойш харвал нээрээ мянган уулсын орой харагдах шиг. Алтай таван Богд, Богд хан, Хөх сэрх, Хасагт хайрхан, Хан хэнтий, Хөгнө хан,Отгонтэнгэр, Цамбагарав, Хорьдол Сарьдаг, Их Богд. Үелээ мянган уулсын бүгдийнх нь орой эндээс л нэгэн зэрэг харагддаг гэлцэнэ. (5)

Хөхрөн дуниартах холын хөх уулс, норсон мэт чийгтэх бор тал, бүх л биеэрээ тарж хэвтээд лугшин буй судасны чимээг газар шороондоо мэдрүүлж, хөнгөн гуних сэтгэлээ хөх өвсөнд нь сэм шивнэн нялхармаар эзгүй хээр. Чухам л энд ижийдээ туних мэт цурхиртал уйлмаар. Ерөөс би энэ л талд татагдан байнга ирдэг бус уу? Энгүй хээр тал намайг ирэхийг чагнаархан, эрмэг түрэмгий салхи нь хүртэл амсхийн тогтоод хүлээдэг юм болов уу. Тал бид хоёр яах аргагүй хүйн холбоотой юм байна аа...(6)

Хөндий салхи нь цэнгэг, жиндүү юм. Хөхрөл уул овоо тань хүндлэл төрөм сүрлэг юм. Богдын орой дээр суугаад л баймаар....Тал нутгаа овоон дээрээс харж, улам дурлав. Зорьж ирэгсэд буцлаа. Уул өөд өгсөж явахад араас минь тууж, түлхэж өгсөн салхи буруу зөрүү гишгэн буухад, энгэр цээжнээс минь тулж түшин дэмнэлээ. (7)

Уулын оройн дээрээс авч шидчих гээд байсан салхи бэлд тогтжээ.

Дундад халхын тэгш өндөрлөг, Дарьгангын тэгш өндөрлөг хэмээн байгаль судлаачид нэрийддэг. Шилийн Богдын ойролцоо 200 орчим унтарсан галт уул байдгийн хамгийн өндөр нь 705 метр Шилийн Богдыг гэдэг юм. Надад Шилийн Богд уул унтарсан галт уул гэхээсээ унтаж буй аварга үлэг гүрвэл мэт санагддаг. Хагас дугуй эвхэрсхийгээд, хошуугаа урагшаа тавьж, түр амсхийн зүүрмэглэж буй аварга том гүрвэл мэт. Хайрст нуруугаар нь авирч хамар дээр нь гарах ч ажирч цочихгүй.(8)

Т.Ганди

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. УНШИХ ЧАДВАР СОРЬСОН ДААЛГАВАР

“Ай Дарьганга нутаг минь**”** эхэд байгаль дэлхийгээ хайрлан дээдлэх, ёс заншлыг өгүүлжээ. Эхийг дараах даалгаврын хүрээнд задлан шинжлээрэй. [25 оноо]

1. 3-р цогцолбороос сонгосон дараах өгүүлбэрийн баймж үнэлэмжийг тайлбарлана уу?. [2оноо]

“...Уул нь маниас өөр олигтой нүдтэй хүнд бол дурансаад байх юмгүй. ...”

.....
.....
.....
.....

2. 1,2,6-р цогцолбороос уран дүрслэлийн аргаар бүтсэн жишээ 4-г олж, дүрслэлийг тайлбарлана уу?. [8оноо]
   - .....
     .....
     .....
   - .....
     .....
     .....
   - .....
     .....
     .....
   - .....
     .....
     .....
   - .....
     .....
     .....
   - .....
     .....
     .....
   - .

3. 5-р цогцолбороос Уул усаа эрхэмлэн дээдэлж, тахин шүтэх ёс заншил хэрхэн илэрснийг 5 баримтаар баталж өөрийн үгээр дүгнэн бичнэ үү? [7 оноо]
   - .....
     .....
     .....
   - .....
     .....
     .....
   - .....
     .....
     .....
   - .....
     .....
     .....
   - .....
     .....
     .....

4. 7-р цогцолборт баймж, үнэлэмж хэрхэн илэрснийг 2 баримтаар батлан, түүнийхээ баймж үнэлэмжийг тайлбарлаж бичнэ үү? [4оноо]
   - .....
     .....
     .....
   - .....
     .....
     .....

5. Төгсгөлийн цогцолбороос эхийн гол санааг илэрхийлэх 2 баримт сонгон, өөрийн үгээр дүгнэн бичнэ үү?. [4 оноо]

ХОЁРДУГААР ХЭСЭГ. БИЧИХ ЧАДВАР СОРЬСОН ДААЛГАВАР

“Ай Дарьганга нутаг минь**”** эхийн бичлэгийн арга барилыг дуурайн, өөрийн нутгийн хайрлан дээдэлдэг уул уснаас нэгийг сонгож,гарчиг өгөн, эх зохион найруулж бичээрэй. Үгийн тоо 250-300 /25 оноо/

Засагч багш нарт зориулав

Даалгаврын дугаар	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Авбал зохих оноо	2	8	7	4	4	5	3	3	2	2	3	2	3	2
Авсан оноо														
Шалгагч багшийн нэр /Овог нэрийг бүтнээр бичнэ/														
Баталгаажуулсан улсын шалгалтын комисс														